

## Ажлын даалгавар

### ИННОВАЦЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН (ИДХ) МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

#### Нэг. Танилцуулга

1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ) Ухаалаг засаг төслийн хүрээнд Инновацыг дэмжих хөтөлбөр (ИДХ) хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Хөтөлбөрийн зорилго нь тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад Засгийн газрын тавьсан тодорхой зорилтуудыг дэмжихэд чиглэсэн нээлттэй өгөгдлийн болон хөдөлгөөнт холбооны аппликэйшн хөгжүүлж, нэвтрүүлэхэд чиглэсэн инновацын төслийг санхүүжүүлэхэд оршино. Уг хөтөлбөр нь дээрх тодорхой зорилтуудыг шийдвэрлэх хамгийн шинэлэг шийдэл бүхий төслийг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын аргаар сонгож, санхүүжүүлнэ. Мөн Ухаалаг засаг төслийн төрийн үйлчилгээний ил тод, хүртээмжтэй, үр ашигтай байдлыг дээшлүүлэх зорилтыг хангахад хувь нэмрээ оруулна. Хөтөлбөр нь эмэгтэйчүүд, залуучуудад зориулсан шинэлэг шийдэл бүхий инновацын төслийг тэдний оролцоотойгоор хэрэгжүүлэхийг дэмжинэ.

2)

Сонгон шалгаруулалтад шалгарсан компани Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ерөнхий удирдлага дор **“Инновацыг дэмжих хөтөлбөрийг удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх”** зөвлөх үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлнэ. Инновацыг дэмжих хөтөлбөрийн урт хугацааны зорилго нь Монгол Улсад мэдээлэл, харилцаа холбооны инновацын соёлыг хөгжүүлэн дэмжихэд орших бөгөөд богино хугацаанд Монгол Улсын хэмжээнд хэрэглэж болох шинэлэг аппликэйшн боловсруулж, хөгжүүлэхийг дэмжих зорилготой. Ухаалаг засаг төслийн хүрээнд уг хөтөлбөрт зориулж 0.4 сая ам.долларын санхүүжилт хуваарилахаар төсөвлөсөн байна. Нээлттэй өгөгдлийн болон хөдөлгөөнт холбооны аппликэйшн хөгжүүлэхэд зориулсан санхүүжилтийг төсөл сонгон шалгаруулах замаар олгоно.

Шалгаруулалтад оролцох аппликэйшн нь иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн байна.

#### Хоёр. Зорилго

Энэхүү зөвлөхийн үйлчилгээний зорилго нь Инновацыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулахад ЗГХЭГ-т дэмжлэг үзүүлэхэд оршино. Зөвлөх компанийн зүгээс дор дурдсан дэмжлэгийг үзүүлнэ. Үүнд:

- 1) Хөтөлбөрийн хүрээнд санхүүжигдэх төслийн заавар, загварыг нарийвчлан боловсруулах,
- 2) Санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлэх;
- 3) Инновацыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтийн журмыг боловсруулж, батлуулах;
- 4) Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ЗГХЭГ-т дэмжлэг үзүүлэх,

- 5) Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
- 6) Хөтөлбөрийн үр дүнг тайлагнах, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

## **Гурав. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ**

### **i) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүтэц, загварыг нарийвчлан боловсруулах**

- a. Инновацыг дэмжих хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын хүрээ, стратегийг дараах үндсэн зарчмаар боловсруулна:
  - Үнэлгээний шалгууруудыг ойлгомжтой тодорхойлсон байх;
  - Сонгон шалгаруулах, гэрээ байгуулах үйл явц ил тод байх;
  - Сонгон шалгаруулах, үнэлэх үйл явц шударга байх;
  - Сонгон шалгаруулах, хэрэгжүүлэх үйл явцад жендерийн тэгш байдлыг хангах;
  - Төслийн амжилттай хэрэгжилтэд тулгуурлан санхүүжилт олгох.
- b. Тогтоосон тодорхой зорилт, зорилтот хэрэглэгч бүхий 10 хүртэл тооны инновацын төслийг шалгаруулж 6-аас доошгүй тооны аппликейшн, үйлчилгээг хөгжүүлнэ.
- c. Төслийн багт нэгээс доошгүй тооны эмэгтэй гишүүн оруулсан байхыг шаардана.
- d. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тогтсон хугацаа, бүтээгдэхүүн, гарах үр дүнгийн хамт боловсруулна.

### **ii) Инновацын хөтөлбөрийн санхүүжилтийн журмыг боловсруулж, батлуулах**

Инновацын хөтөлбөрийн санхүүжилтийн журамд санхүүжилт олгоход баримтлах үндсэн зарчим, дүрмийг тогтоож өгөх бөгөөд хөтөлбөрийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц, сангийн зарцуулалт хэрхэн хийгдэхийг тодорхойлно.

Зөвлөх компани нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ухаалаг засаг төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран энэхүү журмыг эцэслэн боловсруулна. Дараах агуулгатай байна.

- a. Инновацыг дэмжих хөтөлбөрийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц;
- b. Инновацын санхүүжилт олгох төслийн сонгон шалгаруулах шалгуур, гэрээний нөхцөл болзол, санхүүжүүлэх журам;
- c. Гэрээ байгуулах болон зарцуулалтын удирдлагад баримтлах журам.

Энэхүү санхүүжилтийн журмыг Инновацын хөтөлбөрийн санхүүжилтийг олгож эхлэхээс өмнө Дэлхийн Банкны шаардлага хангасан хэлбэр, агуулгаар эцэслэн батлуулсан байна.

### **iii) Хөтөлбөрийн удирдлага**

a. Инновацын хөтөлбөрийн санхүүжилтийн журмын дагуу ИДХ-ийн өдөр тутмын үйл ажиллагаа зохион байгуулах. Зөвлөх компани нь орон даяар инновацын соёл төлөвшүүлэх үүднээс олон нийтэд чиглэсэн арга хэмжээ, сурталчилгааны кампанит ажлуудыг төлөвлөж, зохион байгуулна.

- б. Хөтөлбөрийн бүхий л үйл ажиллагаа, түүний дотор санал авах урилга илгээх, төсөл сонгон шалгаруулах, нарийвчилсан үнэлгээний тайлан гаргах, гэрээ байгуулахаар санал болгох, гэрээний хэлэлцээр хийх, санхүүжилт олгох зэрэгт Захиалагчид дэмжлэг үзүүлж ажиллана.
- в. ИДХ-ийн санхүүжилтийн журмын дагуу зохих санхүүгийн баримтуудыг бүрдүүлж хөтөлбөрөөс санхүүжилт олгоход Ухаалаг засаг төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжид дэмжлэг үзүүлж ажиллана.
- г. ИДХ-ийн хяналт шинжилгээ, үнэлгээний систем (тайлангийн маягт) боловсруулж, хэрэгжүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон хөтөлбөрөөс санхүүжилт хүртэгсдийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.
- д. ИДХ-ийн вэбсайт, мэдээллийн технологийн системийг боловсруулж ажиллуулан, хэвийн ажиллагааг хангаж, ажиллагааны явцад гарсан асуудлыг шийдвэрлэнэ.
- е. Инновацын соёлыг хөгжүүлэн дэмжих, энэ тухай ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч олон нийтийн харилцаа, маркетингийн төлөвлөгөө боловсруулж ажиллана.
- ё. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн зүйлс, авсан сургамжуудыг нэгтгэн хөтөлбөрийн эцсийн тайланг бэлтгэнэ. Эдгээр сургамж, туршлагыг инновацын үйл явцыг сайжруулах, ИДХ-ийг боловсронгуй болгох зөвлөмж гаргах, ИДХ-ийн хэвлэл мэдээллийн хөтөлбөр, сурталчилгааны арга хэмжээ, чуулга уулзалт гэх мэт МХТ-ийн сурталчилгааны үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулахад ашиглана.

### **Дөрөв. Зөвлөх компанид тавигдах шаардлага**

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а. Инновац, гарааны бизнесийн санаачилгуудыг удирдаж ажиллах туршлагатай нь нотлогдсон байх.
- б. Холбогдох Инновац, гарааны бизнесийн чиглэлд санхүүжилт босгох, гарааны бизнес хөгжүүлэх таваас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- в. Хандивлагчид, банк, санхүүгийн байгууллага, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлэх, удирдах, санхүүжүүлэх туршлагатай байх;
- г. Олон нийтийн харилцаа, маркетинг, мэдээлэл сурталчилгааны ажлын туршлагатай байх.

Зөвлөх компани нь дараах мэргэжил, чиглэлийн үндсэн зөвлөхтэй байна.

- **Багийн ахлагч.** ИДХ-ийн төслийн ерөнхий удирдлага, зохицуулалтыг хариуцна.
- **Инновацын төслийн зохицуулагч.** Инновацын тулгамдсан асуудлуудыг гаргаж ирэх, тодорхойлох, тэдгээрийн маркетинг, цахим харилцааны асуудлыг шийдвэрлэх, хариу арга хэмжээг хүлээн авч, дүн шинжилгээ хийх, сонгон шалгаруулалтын удирдлага, гэрээний дараах харилцааг удирдах үүрэгтэй мэргэжлийн менежер байна.
- **Мэдээллийн технологийн мэргэжилтэн.** ИДХ-ийн вэбсайт, МТ-ийн системийг боловсруулж, бий болгож ажиллуулах, түүний жигд ажиллагааг хангахад техникийн дэмжлэг үзүүлэх, ажиллагааны явцад гарч болох асуудлыг шийдвэрлэх зэрэг үүрэг бүхий мэдээллийн технологийн мэргэжилтэн байна.

- **Хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан.** Хяналт шинжилгээ, үнэлгээний систем боловсруулж хэрэгжүүлэх, шалгарсан гэрээлэгчийн ажлын гүйцэтгэлийг Инновацын төслийн зохицуулагчтай хамтран үнэлэх үүрэг бүхий хяналт шинжилгээ, үнэлгээний туршлагатай мэргэжилтэн байна.
- **Захиргаа, санхүүгийн ажилтан.** ИДХ-ийн өдөр тутмын захиргаа, санхүүгийн удирдлага, боловсон хүчин, хангамж, худалдан авалтын асуудлыг хариуцан, санхүүгийн тайланг тогтмол бэлтгэж ИДХ-ийн стратегийн удирдах зөвлөл, бусад оролцогч талуудад тайлагнах үүрэг бүхий нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэргэжилтэн байна.
- **Маркетинг, технологийн сурталчилгааны мэргэжилтэн.** Маркетинг, олон нийтийн нийтийн харилцааны мэргэжилтэй, ялангуяа МХТ-ийг дэмжин сурталчлах чиглэлээр туршлагатай мэргэжилтэн байна. Маркетинг, сурталчилгаа, олон нийтэд таниулах, олон нийттэй харилцах кампанит ажил төлөвлөн зохион байгуулах туршлагатай байвал зохино. Мөн МХТ-ийг дэмжин сурталчлахтай холбоотой ажлууд, түүний дотор инновацын төслийг хэвлэл мэдээллээр сурталчлах хөтөлбөр, арга хэмжээ, хурал чуулганыг төлөвлөх, удирдан зохион байгуулах ажлыг хариуцна.

Зөвлөхийг Дэлхийн Банкны Зөвлөх сонгон шалгаруулж ажиллуулах зааварт заасан Мэдлэг чадварын үнэлгээний дагуу сонгоно.

#### **Тав. Ажил гүйцэтгэх хугацаа, төлбөрийн хуваарь**

Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг 7 сарын хугацаанд хийж гүйцэтгэнэ. Төлбөрийн хуваарийг Зөвлөх үйлчилгээний гэрээгээр харилцан тохиролцож тогтооно.

#### **Зургаа. Үр дүнгийн бүтээгдэхүүн, тайлангийн шаардлага**

Зөвлөх компани нь ЗГХЭГ-т ажлаа хариуцан тайлагнах бөгөөд Ухаалаг засаг төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-тэй нягт хамтран ажиллана. Шаардлагатай үед зөвлөх багийн гишүүд орон нутагт томилолтоор ажиллана.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд дараах, төлөвлөгөө, тайланг бэлтгэнэ.

<b>Бүтээгдэхүүн</b>	<b>Хэлбэр</b>	<b>Давтамж</b>	<b>Тайлагнах</b>
Сар тутмын явцын тайлан	Файлаар, цаасаар	7 удаа	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Хөтөлбөрийн бүтцийн дэлгэрэнгүй тайлан, түүний дотор мэдээлэл сурталчилгааны ажлын тайлан	Файлаар, цаасаар	1 удаа	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Санхүүжилтын журмын эцсийн батлагдсан хувилбар	Файлаар, цаасаар	1 удаа	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Төслийн санал бэлтгэж ирүүлэх заавар, загвар	Файлаар, цаасаар	1 удаа	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх

Сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, эрх олгох зөвлөмжүүд	Файлаар, цаасаар	1 удаа	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Гэрээний төсөл, хэлэлцээр	Файлаар, цаасаар	Төсөл тус бүрээр	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Үйл ажиллагааны төлөвлөгөө, ажил гүйцэтгэх хуваарь	Файлаар, цаасаар	Улиралд	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Олон нийтийн харилцаа, маркетинг, мэдээлэл сурталчилгааны төлөвлөгөө	Файлаар, цаасаар	1 удаа	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Хяналт шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, тайлан	Файлаар, цаасаар	2 удаа	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Төсөл, арга хэмжээ бүрийн санхүүгийн тайлан	Файлаар, цаасаар	Санхүүжүүлсэн төсөл бүрээр	ЗГХЭГ-т илгээж хувийг ТХН-д ирүүлэх
Олон нийтийн харилцаа, маркетингийн ажлын тайлан	Файлаар, цаасаар	1 удаа	ЗГХЭГ хувийг ТХН
Төслийн эцсийн тайлан	Файлаар, цаасаар	1 удаа	ЗГХЭГ хувийг ТХН

### **Долоо. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас үзүүлэх дэмжлэг**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Зөвлөх компанид дараах дэмжлэг, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ. Үүнд:

- а. Мэдээллээр хангах: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар уг зөвлөх үйлчилгээтэй холбоотой бүхий л өгөгдөл, мэдээллээр Зөвлөхийг хангана;
- б. Нэвтрэх боломж: Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавартай холбоотойгоор Засгийн газрын харьяа байгууллага, орон нутгийн захиргаад, тэдгээрийн удирдлагатай уулзах, мэдээлэл авах ажлыг зохион байгуулна.